



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд аймгийн Мал эмнэлэгийн газрын 2022 оны санхүүгийн тайланд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/34/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Ховд хот
2023 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар
Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn
Аудитын менежер: А.Цэцэгсүрэн
Утас: 70432545
Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn
Аудитор: С.Оюунжаргал
Утас: 99911390
Цахим хаяг: Oyunjargais@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.5.1 Төсвийн төлөвлөлт	13
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	13
3.5.3 Нэмэлт төсөв	14
3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн	14
4. АУДИТЫН ТАЙЛАН	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.5.1 Завсрын аудитын талаар	Error! Bookmark not defined.
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	Error! Bookmark not defined.
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	16
5.1 Залруулсан алдаа	Error! Bookmark not defined.
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХААХҮЯ	Хүнс хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яам
ӨХЗ	Өмч хамгаалах зөвлөл
МЭЕГ	Мал эмнэлэгийн ерөнхий газар
УИХ	Улсын Их Хурал
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
УМЭАЦТЛ	Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лаборатор
МЭҮН	Мал эмнэлэгийн үйлчилгээний нэг



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

ХОВД АЙМГИЙН МАЛ ЭМНЭЛЭГИЙН
ГАЗРЫН ДАРГА Д.БАТЦЭНГЭЛ ТАНАА

2023.02.07 № 02/3
танай _____-ны № _____-т

ХЯЗГААРЛАЛТАЙ ДҮГНЭЛТ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мөнххайрхан сумын Байгалийн цогцолборт газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мал эмнэлгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар шүүхийн шийдвэр гүйцэтгэлээр байгууллагын төсвөөс олгосон ажлаагүй хугацааны цалин хөлсийг буруутай албан тушаалтнаар төлүүлээгүй авлага үүсгэсэн, анхан шатны баримтгүй шатахуун зарцуулсан, төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй зэрэг 99.2 сая төгрөгийн зөрчил нь Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, АДБОУС 1250, иж бүрэн, тасалбар болголт нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор 2022 онд малын гоц халдварт шүлхий өвчин гарсантай холбоотой 6 удаагийн дархлаажуулалтаар 17 сумын 641.6 мянган толгой малд 583.2 мянган тун 478.5 сая төгрөгийн вакцин тарьж МЭҮН-үүдэд 337.0 сая төгрөгийн дархлаажуулалтын үйлчилгээний хөлсийг улсын төсвөөс олгожээ. Мөн орон нутгийн төсвөөс 111.8 сая төгрөгийг шүлхийн голомтод ажилласан эмч нарын томилолт, шатахуун халдвар хамгааллын хэрэгсэлд зарцуулжээ.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсноор тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

МЭЕГ-ын даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд бодлогын баримт бичигт тусгагдсан 7 зорилтын 49, Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах 2 зорилтын хүрээнд 5, хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэхэд 1 зорилтын хүрээнд 2, хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх 3 зорилтын хүрээнд 7 арга хэмжээ нийт 13 зорилтын хүрээнд 63 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд хэрэгжилт 99.7 хувьтай үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



X. Болдбаатар

Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	625300199.10	669464927.08
33	АВЛАГА	0.00	35929924.00
335	Бусад авлага	0.00	35929924.00
3351	Байгууллагаас авах авлага	0.00	20298227.00
3353	Ажилчдаас авах авлага	0.00	15631697.00
34	УРЬДЧИЛГАА	7200000.00	6000000.00
34600	Урьдчилж гарсан зардал	7200000.00	6000000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	618100199.10	627535003.08
351	Түүхий эд материал	217309267.39	178642580.36
35130	Эм боох материал	217309267.39	178642580.36
354	Хангамжийн материал	400790931.71	448892422.72
35410	Бичиг хэргийн материал	4328350.00	3410151.00
35420	Аж ахуйн материал	18825457.60	18813457.60
35430	Сэлбэг хэрэгсэл	741800.00	4741800.00
35440	Түлш, шатах тослох материал	0.00	2635000.00
35470	Бусад хангамжийн материал	376895324.11	419292014.12
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	765738519.90	683606009.16
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	765738519.90	683606009.16
392	Биет хөрөнгө	732623519.74	650847257.96
39201	Барилга, байгууламж, орон сууц	316131151.72	316131151.72
39202	Хуримтлагдсан элэгдэл	-17219157.36	-23063743.20
39203	Авто-тээврийн хэрэгсэл	888614000.15	888614000.15
39204	Хуримтлагдсан элэгдэл	-727188107.49	-765127018.20
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	398214380.60	417663399.60
39206	Хуримтлагдсан элэгдэл	-335396203.02	-365167650.14
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	44792388.06	47122388.06
39208	Хуримтлагдсан элэгдэл	-20231525.20	-23932556.67
39214	Бусад үндсэн хөрөнгө	284908990.20	284908990.20
39215	Хуримтлагдсан элэгдэл	-100002397.92	-126301703.56
393	Биет бус хөрөнгө	33115000.16	32758751.20
39301	Програм хангамж	4140000.00	4140000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2224999.84	-2581248.80
39303	Бусад биет бус хөрөнгө	31200000.00	31200000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1391038719.00	1353070936.24
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	47353300.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	47353300.00
413	Өглөг	0.00	47353300.00
4136	Бусад өглөг	0.00	47353300.00
41361	Байгууллагад төлөх өглөг	0.00	47353300.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1391038719.00	1299717636.24
51	Засгийн газрын хувь оролцоо	1391038719.00	1299717636.24
512	Хуримтлагдсан үр дүн	1254654908.45	1169333825.69
51210	Өмнөх үеийн үр дүн	1317583114.40	1254381992.91

51220	Тайлант үеийн үр дүн	-62928205.95	-85048167.22
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	136383810.55	136383810.55
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI-IV+V	1391038719.00	1353070936.24

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
i	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (i)	3158239792.83	2437333445.64
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1305299185.69	661874994.68
120	Нийтлэг татварын бус орлого	1305299185.69	661874994.68
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1305299185.69	661874994.68
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3000400.00	3927700.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1302298785.69	657947294.68
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1852940607.14	1775458450.96
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	945825200.00	949598200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	945825200.00	949598200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	907115407.14	825860250.96
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	543779526.50	538505100.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	278724510.00	261263050.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	84611370.64	26092100.96
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3221167998.78	2522381612.86
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3221167998.78	2522381612.86
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3136283126.44	2485737669.66
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	568296166.67	566795976.05
210101	Үндсэн цалин	420856220.96	368822738.24
210102	Нэмэгдэл	129929809.23	118904890.55
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17510136.48	41732400.00
210104	Урамшуулал	0.00	37335947.26
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78210283.49	77489245.34
210201	Тэтгэврийн даатгал	53075743.54	49494748.20
210202	Тэтгэмжийн даатгал	5454734.15	5813005.01
210203	ҮОМШӨ-ний даатгал	8152992.21	10255247.49
210204	Ажилгүйдлийн даатгал	988713.05	1070347.61
210205	Эрүүл мэндийн даатгал	10538100.54	10855997.03
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28115281.70	29684800.00
210301	Гэрэл, цахилгаан	4081403.70	4994400.00
210302	Түлш, халаалт	22224950.00	22913600.00
210303	Цэвэр, бохир ус	1808928.00	1776800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	62321678.04	107872794.14

210401	Бичиг хэрэг	6670760.00	6968408.00
210402	Тээвэр, шатахуун	49591250.00	61383075.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4476078.04	5214311.41
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1583590.00	12900.00
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	0.00	34294099.73
2105	Нормативт зардал	330826220.83	776661608.80
210501	Эм, бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	330826220.83	776203808.80
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	457800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1350000.00	150000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	150000.00
210604	Урсгал засвар	1350000.00	0.00
2107	Томилолт, зочны зардал	8581900.00	2271100.00
210702	Дотоод албан томилолт	8581900.00	2271100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	819795262.50	759849090.76
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	813873454.50	751957522.76
210803	Даатгалын үйлчилгээ	1467500.00	1500000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	483708.00	573568.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	370600.00	148000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3600000.00	5670000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1238786333.21	164963054.57
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1119304739.25	61324440.37
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	119481593.96	103638614.20
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	84884872.34	36643943.20
2132	Бусад урсгал шилжүүлэг	2667450.00	1667800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2667450.00	1667800.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	82217422.34	34976143.20
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	82217422.34	34976143.20
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-62928205.95	-85048167.22

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1855941007.14	1779416150.96
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3000400.00	3927700.00
120	Нийтлэг татварын бус орлого	3000400.00	3927700.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3000400.00	3927700.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3000400.00	3927700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1852940607.14	1775488450.96
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	945825200.00	949598200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	945825200.00	949598200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	907115407.14	825890250.96
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	543779526.50	538505100.00

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	278724510.00	261263050.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	84611370.64	26122100.96
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1844091007.14	1761666650.96
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1844091007.14	1761666650.96
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1759206134.80	1725022707.76
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	570796166.67	582478602.05
210101	Үндсэн цалин	420816220.96	384505364.24
210102	Нэмэгдэл	132469809.23	118904890.55
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17510136.48	41732400.00
210104	Урамшуулал	0.00	37335947.26
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	76210263.49	77489245.34
210201	Тэтгэврийн даатгал	53075743.54	49494746.20
210202	Тэтгэмжийн даатгал	5454734.15	5813005.01
210203	ҮОМШӨ-ний даатгал	8152992.21	10255247.49
210204	Ажилгүйдлийн даатгал	988713.05	1070347.61
210205	Эрүүл мэндийн даатгал	10538100.54	10955897.03
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28115281.70	29684800.00
210301	Гэрэл, цахилгаан	4081403.70	4994400.00
210302	Түлш, халаалт	22224950.00	22913600.00
210303	Цэвэр, бохир ус	1808928.00	1776800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	27990818.04	24032831.41
210401	Бичиг хэрэг	8422500.00	3902180.00
210402	Тээвэр, шатахуун	13326200.00	13499020.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4607678.04	5272831.41
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1634440.00	1358800.00
2105	Нормативт зардал	136492752.40	20827510.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	133985752.40	18604710.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2507000.00	2222800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3007750.00	6338100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	598300.00	961300.00
210604	Урсгал засвар	2409450.00	5376800.00
2107	Томиллолт, зочны зардал	8581900.00	2271100.00
210702	Дотоод албан томиллолт	8581900.00	2271100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	905857882.50	981780618.96
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	892736074.50	978689050.96
210803	Даатгалын үйлчилгээ	1467500.00	1500000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	483708.00	573568.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	370600.00	148000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10800000.00	870000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	153300.00	119900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	153300.00	119900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	84884872.34	36643943.20

2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2667450.00	1667800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2667450.00	1667800.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	82217422.34	34976143.20
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	82217422.34	34976143.20
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	11850000.00	17749500.00
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	0.00	0.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	11850000.00	17749500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	11850000.00	17749500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	11850000.00	17749500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	11850000.00	17749500.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-11850000.00	-17749500.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	136383810.55	1317583114.40	1453966924.95
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	136383810.55	1317583114.40	1453966924.95
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	136383810.55	1317583114.40	1453966924.95
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	136383810.55	1317583114.40	1453966924.95
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	136383,810.55	1317583114.40	1453966924.95
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	136,383,810.55	1254381992.91	1390765803.46
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-85,048,167.22	-85,048,167.22
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	136383810.55	1169333825.69	1305717636.24

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	953598200.00	918549756.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	953598200.00	918549756.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	951930400.00	916881956.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	615872700.00	582478602.05
210101	Үндсэн цалин	383595700.00	384505364.24
210102	Нэмэгдэл	143334000.00	118904890.55
210103	Унаа хоолны хөнгөлөлт	41936800.00	41732400.00
210104	Урамшуулал	47006200.00	37335947.26
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78094200.00	77489245.34
210201	Тэтгэврийн даатгал	49104000.00	49494748.20
210202	Тэтгэмжийн даатгал	6247600.00	5813005.01
210203	ҮОМШӨ-ний даатгал	9598000.00	10255247.49
210204	Ажилгүйдлийн даатгал	1249600.00	1070347.61
210205	Эрүүл мэндийн даатгал	11895000.00	10855897.03
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29684800.00	29684800.00
210301	Гэрэл, цахилгаан	4994400.00	4994400.00
210302	Түлш, халаалт	22913600.00	22913600.00
210303	Цэвэр, бохир ус	1776800.00	1776800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24032900.00	24032831.41
210401	Бичиг хэрэг	3833000.00	3902180.00
210402	Тээвэр, шатахуун	13410200.00	13499020.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5348000.00	5272831.41
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1441700.00	1358800.00
2105	Нормативт зардал	20851300.00	20827510.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	18628200.00	18604710.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2223100.00	2222800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6338100.00	6338100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	961300.00	961300.00
210604	Урсгал засвар	5376800.00	5376800.00
2107	Томилолт, зочны зардал	2500000.00	2271100.00
210702	Дотоод албан томилолт	2500000.00	2271100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	174436500.00	173639868.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	170548300.00	170548300.00
210803	Даатгалын үйлчилгээ	1500000.00	1500000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	882200.00	573568.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	636000.00	148000.00

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	870000.00	870000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	119900.00	119900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	119900.00	119900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1667800.00	1667800.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1667800.00	1667800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1667800.00	1667800.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	953598200.00	918549756.80
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	949592800.00	914622056.80
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	949592800.00	914622056.80
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	4000000.00	3927700.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	4000000.00	3927700.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	41.00	41.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	0.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	52.00	40.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	48.00	37.00
620003	Үйлчлэх ажилтан	3.00	3.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	0.0	0.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	825890250.96
21	УРСГАЛ ЗАРДАЛ	825890250.96
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	825890250.96
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	825890250.96
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	825890250.96
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	825890250.96
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	825890250.96
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	538505100.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	261263050.00

131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	26122100.96
--------	------------------------------------------------------------------------------	-------------

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Ховд аймгийн Мал эмнэлэгийн газар нь мал амьтны эрүүл мэндийг хамгаалах, түүхий эд бүтээгдэхүүний эрүүл аюулгүй байдлыг баталгаажуулах, нийтийн эрүүл мэндийг хамгаалах замаар мал эмнэлэгийн салбарын оновчтой нэгдсэн бодлогоор хангагч, худалдааны чөлөөт байдлыг дэмжигч байгууллага болно гэсэн эрхэм зорилго тодорхойлжээ. Дээрх зорилгыг хэрэгжүүлэхээр дараах зорилтуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнд:

- Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах
- Мал амьтны эрүүл мэнд нийтийн эрүүл мэндийг хамгаалах албанд төрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах, хяналт тавин хэрэгжүүлэх
- Хуулийн хүрээнд батлагдсан журам, дүрэм заавар, стандарт норм, нормативыг мөрдөх, мөрдүүлэх
- Мал амьтны эрүүл мэндийг хамгаалах талаар УИХ, засгийн газар ХХААХҮЯ, МЭЕГ, аймгийн ИТХ, Засаг дарга, Онцгой байдлын газар бусад холбогдох байгууллагаас гаргасан тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх
- Малын эрүүл мэнд дэд хөтөлбөр, халдварт өвчинтэй тэмцэх бэлэн байдлын төлөвлөгөө, шимэгчлэх өвчнийг эмчлэн сэргийлэх үйл ажиллагааны хөтөлбөр бусад бодлогын баримт бичгийг батлуулж хэрэгжилтийг хангах
- Сумын мал эмнэлэгийн тасаг, МЭҮН-үүдийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах
- Ховд аймгийн Малын эрүүл мэндийн бүртгэл мэдээллийн сан байгуулах
- Хүнсний аюулгүй байдал нийгмийн эрүүл мэндийг хамгаалах

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөх Төрийн хэмнэлтийн тухай хууль шинээр батлагдаж хэрэгжиж байна.

ХХААХҮ-ийн сайдын 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн А/24 тоот тушаалаар Ховд аймгийн Мал эмнэлэгийн газрыг 51 орон тоотой байхаар баталсан байна. Удирдах 1 гүйцэтгэх 36, үйлчилгээний 3 нийт 40 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна. Төрийн албаны зөвлөлөөс тогтоол гарч төрийн албаны шалгалтад орсон албан хаагчид тэнцээгүйн улмаас зарим сумдад улсын байцаагчгүй үйл ажиллагаа явуулж байна.

Тус газар нь 2022 оны үйл ажиллагаа хууль тогтоомж тогтоол шийдвэрийн хэрэгжилт засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт аймаг нийслэлийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт аймаг нийслэлийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, эдийн засаг нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ засгийн газрын гишүүн аймаг нийслэлийн засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт байгууллагын ил тод байдлын үнэлгээ тайлангуудын биелэлтэд хяналт шинжилгээ хийхэд ерөнхий дундаж 97.7 хувьтай дүгнэгдсэн байна.

2022 онд малын гоц халдварт шүлхий өвчин гарсантай холбоотой 6 удаагийн дархлаажуулалтаар 17 сумын 641.6 мянган толгой малд 583.2 мянган тун 478.5 сая төгрөгийн вакцин тарьж МЭҮН-үүдэд 337.0 сая төгрөгийн дархлаажуулалтын үйлчилгээний хөлсийг улсын төсвөөс олгожээ. Мөн орон нутгийн төсвөөс 111.8 сая төгрөгийг шүлхийн

голомтод ажилласан эмч нарын томилолт, шатахуун халдвар хамгааллын хэрэгсэлд зарцуулжээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль зэрэг хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт **үр нөлөөтэй** байна.

Байгууллагын даргын 2022 оны А/31 тушаалаар байгуулагдсан өмч хамгаалах зөвлөл тус байгууллагын өмч хөрөнгийн ашиглалт, хадгаалт, хамгаалахад хяналт тавин ажиглаж байна. Тайлант онд дотоод аудит, хяналт, шинжилгээ үнэлгээний газраас тус онд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Тайлант онд ТӨБЗГ-ын 2022 оны 02 дугаар 22-ны өдрийн 64 дүгээр тогтоолын дагуу Мал эмнэлэгийн газрын даргын 2022 оны 06 дугаар сарын 21-ний А/45 дугаар тушаалаар төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогын ажлыг зохион байгуулах ажлын хэсэг 6 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилж, тооллогыг зохион байгуулж хөрөнгө бүртгэн авах, актлах хөрөнгийг шийдвэрлүүлэх талаар санал дүгнэлтийг гаргажээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах **шаардлагагүй** гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн Мал эмнэлэгийн газар нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад **нийцсэн** тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Мал эмнэлэгийн газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 366 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 43.9 сая төгрөгөөр буюу 0.03 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	7,200.0	35,929.9	28,729.9
Бараа материал	618,100.2	627,535.0	9,434.8
Үндсэн хөрөнгө	765738.5	683606.0	(82,132.5)
Нийт хөрөнгө	1,391,038.7	1,347,070.9	(43,967.8)
Өрт төлбөр		47,353.3	47,353.3
Засгийн газрын хувь оролцоо/Эздийн өмч	1,391,038.7	1,299,717.6	(91,312.1)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,391,038.7	1,347,070.9	(43,967.8)

Дансны үлдэгдэлд гарсан дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- ✓ Мал эмнэлэгийн газрын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх авлагын дүн 28729.9 сая төгрөгөөр өссөн нь Биомед трейд ХХК-иас малын эхо аппарат худалдан авах 19500.0 төгрөгийн гэрээ байгуулсан ч бараа хугацаандаа ирээгүй, шүүхийн шийдвэрийн дагуу 2 албан хаагчийн ажилгүй байсан хугацааны цалин байгууллагын төсвөөс олгосонтой холбоотой авлага өссөн байна.
- ✓ Бараа материал 9434.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь нэг удаагийн халдвар хамгааллын хэрэгсэл, авто машин дугуй аккумулятор шинээр авсан нь нөлөөлжээ
- ✓ Өр төлбөр 47353.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь 2022 онд бруцеллөз өвчний дархлаажуулалтын үйлчилгээний хөлсний санхүүжилт дутуу орж ирснээс өр үүссэн
- ✓ Нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 43967.8 мянган төгрөгөөр, засгийн газрын хувь оролцоо 91312.1 мянган төгрөгөөр тус тус буурсан нь үндсэн хөрөнгийн элэгдэл байгуулсантай тус тус холбоотой өөрчлөлт орсон байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 888,031.5 мянган төгрөг, Орон нутгийн төсвөөс 462,746.6 мянган төгрөг, өөрийн орлогоос 2,000.0 мянган төгрөг нийт 1,352,778.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөвт тодотгол хийсэн байна. Эх үүсвэрийг Улсын төсөв 949,598.2 мянган төгрөг, орон нутгаас 455,505.1 мянган төгрөг, Төсвийн захирагчийн төсвөөс, өөрийн орлогоос 4,000.0 сая төгрөгийг бүрдүүлэхээр өөрчлөлт оруулсан

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 949,598.2 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 455505.1 мянган төгрөг өөрийн орлогоос 3,927.7 мянган төгрөг нийт 1,409,031.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1377982.5 мянган төгрөг буюу 97.8 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 34976.1 мянган төгрөгөөр хэмнэж төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Хөтөлбөр арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	Биелэлт
1	70801/80101	487,887.9	483,190.10	4,697.80	99
2	70801/82502	41,858.3	41,858.3	0.00	100
3	70801/82507	128,690	128,690	0.00	100
4	70801/82510	1,700.0	1,700.0	0.00	100
5	70805/80101	272,494.2	242,215.80	30,278.40	88.8
6	70805/80802	1,667.8	1,667.8	0.00	100
	Дүн	949,598.2	914,622	34,976.2	96

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар аймгийн ЗДНХ-өөс 83,000.0 мянган төгрөг, МЭЕГ болон УМЭАЦ-ийн төв лабораториос нийт 261,263.0 мянган төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд 26,122.1 мянган төгрөг нийт 370,385.1 сая төгрөг бүрдүүлж 2022 онд боом, галзуу, сахуу, шүлхий өвчний дархлаажуулалтын үйлчилгээний хөлс, тандалт шинжилгээний тоног төхөөрөмж, оношлуур, тээвэр шатахуун, томилолт, туслах ажилтны цалин зэрэг зардлуудад зарцуулж бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж дансанд тайлагнасан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөр байхгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Мал эмнэлэгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн орлогын гүйцэтгэл, хөрөнгө, бараа материалтай холбоотой зөвлөмж тусгасан.

Аудитыг аудитор С.Оюунжаргал 2023 оны 01 дүгээр сарын 31-ны өдрөөс 02 дугаар сарын 07-ний хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 32 албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материалын байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,528,381.6 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 37,929.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 30343.8 мянган төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага хуулиар хориглосон дарах зардлуудыг санхүүжүүлсэн байна.

4.3.1 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан цахим худалдан авалттай холбоотой "Биомед трейд" ХХК-иас 19,500.0 мянган төгрөгийн зөөврийн эхо Z50 аппаратыг цахим дэлгүүрт худалдан авах хүсэлт байршуулахгүйгээр шууд худалдан авах гэрээ байгуулж төлбөрийг шилжүүлсэн.

4.3.2 Мал эмнэлэгийн байгууллага үүсэж хөгжсөний 100 жилийн ой 2023 онд тохиож байхад 2022 оны төсвөөс ойн арга хэмжээний зардал/ кино, шторк, эрдэм шинжилгээний хурал, баярын хурлын нэвтрүүлэг/ хийлгэхээ төрийн бус байгууллагатай гэрээ хийж 6000.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон ч авлагаар бүртгээгүй, хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэл тодорхой бус байгаа тул тайланд урьдчилж гарсан зардлаар бүртгүүлэн дараа онд гэрээний хэрэгжилтийг хянан үзэх шаардлагатай гэж үзлээ.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд тендерт шалгарсан оролцогчийн мэдээлэл, таван саяас дээш орлого, зарлагын гүйлгээг бүрэн мэдээлж, 20 тушаал шийдвэрээс 18-ийг мэдээллээгүй, байсныг аудитын явцад залруулан мэдээллүүллээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитаар өгөгдсөн 3791.0 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт барагдаж 10265.4 мянган төгрөгийн 4 зөвлөмж өгөгдсөнөөс 3 бүрэн хэрэгжиж 1 зөвлөмж хэрэгжээгүй байна.

Хүснэгт 3 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүпэлт	/мянган төгрөгөөр/				
	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	3,791.0	1	3,791.0	100
Албан шаардлага	1	-	1	-	90
Зөвлөмж	4	10,265.4	3	10,265.4	75.0
Нийт дүн	7	14,056.4	5	14,056.4	88.3

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар Био мед трейд ХХК-иас малын эхо аппарат авах худалдан авах гэрээний хэрэгжилтийг авч үзэх шаардлагатай гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 6000.0 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 6000.0 мянган төгрөгийн алдааг залрууллаа.

Үүнд: Ойн арга хэмжээний нэвтрүүлэг хийх ажлыг хүлээж аваагүй байхад тайланд хугацааны зардлаар бүртгэсэн байсныг урьдчилж гарсан зардал дансанд залруулаа хийв.

Аудитаар нийт 99.2 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 1.8 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 77.2 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 20.3 сая төгрөгийн зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

- ✓ Албан хаагчдад зөвлөгөөний бэлтгэл ажил хангуулах, зөвлөгөөнд оролцуулах ажлаар 292 цагийн 1840.9 мянган төгрөгийн анхан шатны баримтаар нотлогдохгүй илүү цаг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалтуудыг зөрчсөн, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.2 Албан шаардлага

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

- ✓ 2 албан хаагчийн ажлаагүй хугацааны цалин 15682.6 мянган төгрөгийг мал эмнэлэгийн газраас гаргуулахаар гаргасан шүүгчийн захирамжийн дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага гүйцэлдүүлсэн, буруутай этгээдээр төлүүлээгүй нь Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.2-т "Төрийн албан хаагч албан үүргээ зөрчсөн гэм буруутай үйлдэл/эс үйлдэх/-ийн улмаас бусдад гэм хор учруулсан бол уг гэм хорыг түүний ажиллаж байгаа хуулийн этгээд буюу төр хариуцан арилгана, энэ хуулийн 498.5-т энэ хуулийн 498.2-т заасан этгээд өөрийн шууд санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлээр гэм учруулсан бол гэм хорыг арилгасан байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс гаргуулахыг шаардах эрхтэй..., гэж заасныг тус тус зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна
- ✓ Аудитаар 1-6 дугаар саруудын шатахуун түүвэрлэн үзэхэд спидометрийн заалтыг баримтлаагүй, тулгасан баримтуудын мэдээлэл зөрчилтэй, дуудлагын бүртгэлгүй, жолоочийн тооцоо бодоогүй, гарын үсгээр баталгаажуулаагүй, шатахууны зарцуулалтад тавих дотоод хяналт сул, газрын дарга томилолт удирдамжгүйгээр шатахуун зарцуулсан, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт хангагдаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" Төсвийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 13.7. Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно. 16-р зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.3 Зөвлөмж

5.3.1 Үндсэн хөрөнгөтэй холбоотой

Илрүүлэлт: "Биомед трейд" ХХК-иас 19,500.0 мянган төгрөгийн зөөврийн эхс Z50 аппаратыг цахим дэлгүүрт худалдан авах хүсэлт байршуулахгүйгээр шууд худалдан авах гэрээ байгуулж төлбөрийг шилжүүлсэн зөрчил нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ" 14.2. Худалдан авах бараа, үйлчилгээний төрөл нэмэгдэх тохиолдолд энэ хуулийн 14.1-д зааснаар хүсэлтийг тухай бүр хүргүүлнэ гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж : 10 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй бараа ажил үйлчилгээ худалдан авахдаа ТӨБЗГ-т саналаа хүргүүлж, цахим дэлгүүрээс худалдан авалт хийж, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах

5.3.2 Өглөг авлагатай холбоотой

Илрүүлэлт: Нийгмийн даатгалын НД-7Б маягтаар 844.1 мянган төгрөгийн авлагатай тайлагнасан ч санхүүгийн тайланд тусгаагүй нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" 6-р зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх " гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагын тооцоог дахин хийж, шимтгэлийн авлагыг үнэн зөв тайлагнаж, 2023 оны 1 дүгээр улиралд тооцоо нийлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/					
							Үүнээс		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	Залруулаагүй	Тоо	Дүн		
Гэрээгээр гүйцэтгэлүүлсэн ажлыг хүлээж аваагүй байхад тайланд хугацааны зардлаар бүртгэсэн	1.0	6,000.0	-	-	1.0	6,000.0	1.0	6,000.0	-	-	-	-
Дүн	1.0	6,000.0	-	-	1.0	6,000.0	1.0	6,000.0	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	/мянган төгрөгөөр/							
	Нийт алдаа		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Албан хаагчдад зөвлөгөөний бэлтгэл ажил хангуулах, зөвлөгөөнд оролцуулах ажлаар 292 цагийн төгрөгийн илүү цагийн нэмэгдэл хөлс олгосон	1	1,840.90	1	1,840.9				-
2 албан хаагчийн ажлаагүй хугацааны цалинг мал эмнэлгийн газраас гаргуулахаар гаргасан шүүгчийн захирамжийн дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага гүйцэлдүүлсэн, буруутай этгээдээр төлүүлээгүй зөрчил илэрлээ.	1	15,682.60			1	15,682.6		-
Спидометрийн заалтыг баримтлаагүй, тулгасан баримтуудын мэдээлэл зөрчилтэй, дуудлагын бүртгэлгүй, жолоочийн тооцоо бодоогүй, гарын үсгээр баталгаажуулаагүй, шатахууны зарцуулалтад тавих дотоод хяналт сул, газрын дарга томилот удирдамжгүйгээр шатахуун зарцуулсан, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт хангагдаагүй байна	1	61,383.00			1	61,383.0		-
Нийгмийн даатгалын НД-7Б маягтаар 844.1 мянган төгрөгийн авлагатай тайлагнасан ч санхүүгийн тайланд балансад тусгаагүй зөрчил илэрлээ	1	844.10					1	844.1
Дүн	4	79,750.60	1	1,840.9	2	77,065.6	-	844.10

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Төлбөрийн акт		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
"Биомед трейд" ХХК-иас зөөврийн эхо Z50 аппаратыг цахим дэлгүүрт худалдан авах хүсэлт байршуулахгүйгээр шууд худалдан авах гэрээ байгуулж төлбөрийг шилжүүлсэн	-	-	-	-	-	-
Дүн	1.0	19,500.0			1.0	19,500.0
Нийт дүн	1.0	19,500.0			1.0	19,500.0

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Х.БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР:  А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТОР:  С.ОЮУНЖАРГАЛ



ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 06 сарын 07 өдөр

Дугаар 03/2170430

Ховд

ХОА-2022/34/НА-СТА-ТШЗ

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Ховд аймгийн Мал эмнэлэгийн газрын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар ажлаас чөлөөлөгдсөн нэр бүхий хоёр албан хаагчийн ажиллаагүй хугацааны цалин 15682.6 мянган төгрөгийг буруутай этгээдээр төлүүлээгүй зөрчил илэрлээ.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103.1 "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ" Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.2-т "Төрийн албан хаагч албан үүргээ зөрчсөн гэм буруутай үйлдэл/эс үйлдэх/-ийн улмаас бусдад гэм хор учруулсан бол уг гэм хорыг түүний ажиллаж байгаа хуулийн этгээд буюу төр хариуцан арилгана, энэ хуулийн 498.5-т энэ хуулийн 498.2-т заасан этгээд өөрийн шууд санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлээр гэм учруулсан бол гэм хорыг арилгасан байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс гаргуулахыг шаардах эрхтэй." гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Буруутай албан тушаалтнаар 15682.6 мянган төгрөгийг төлүүлж авлага бууруулж ажиллах
2. Албан шаардлагын биелэлтийг 2023 оны 06 дугаар сарын 15-ний дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Мал эмнэлэгийн газрын дарга Д.Батцэнгэл нягтлан бодогч Л.Энхтуул нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Х.БОЛДБААТАР
С.ОЮУНЖАРГАЛ

¹ Монгол Улс, Ховд аймаг, Жаргалант сум, Цамбагарав баг, Засаг даргын Тамгын газрын байр, 3 давхар Утас: 70433061

021040009



ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 02 сарын 07 өдөр

Дугаар 02/2170430

Ховд

ХОА-2022/34/НА-СТА-ТШЗ
ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Ховд аймгийн Мал эмнэлэгийн газрын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар спидометрийн заалтыг баримтлаагүй, тулгасан баримтуудын мэдээлэл зөрчилтэй, дуудлагын бүртгэлгүй, жолоочийн тооцоо бодоогүй, гарын үсгээр баталгаажуулаагүй, шатахууны зарцуулалтад тавих дотоод хяналт сул, газрын дарга томилолт удирдамжгүйгээр шатахуун зарцуулсан, өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй 61.3 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах” нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д “анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно.” 13.7-д “анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх санхүүгийн тайланд тусгахыг хориглоно, Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуй нэгж байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” Зам, Тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт “автомашинь 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм баримтлах” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шатахууны тооцоо бодож хэвших, зарцуулалтыг баримтаар баталгаажуулах, дотоод хяналт болон бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж 61.3 сая төгрөгийн албан шаардлагын биелэлийг 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэх
2. Цаашид алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Мал эмнэлгийн газрын дарга Д.Батцэнгэл, нягтлан бодогч Л.Энхтуул нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Х.БОЯДБААТАР

С.ОЮУНЖАРГАЛ

¹ Монгол Улс, Ховд аймаг, Жаргалант сум, Цамбагарав баг, Засаг даргын Тамгын газрын байр, 3 давхар Утас: 70433061

021040011



ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2023 оны 02 сарын 07 өдөр

Дугаар 04/2170430

Ховд

ХОА-2022/34/НА-СТА-ТШЗ

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Ховд аймгийн Мал эмнэлэгийн газрын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар Албан хаагчдад зөвлөгөөний бэлтгэл ажил хангуулах, зөвлөгөөнд оролцуулах ажлаар 292 цагийн 1840.9 мянган төгрөгийн анхан шатны баримтаар нотлогдохгүй илүү цаг олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь**

1. Дээрх зөрчилтэй холбоотой 1840.9 мянган төгрөг / нэг сая найман зуун дөчин мянга есэн зуун/-ийг хавсралтад дурдсан нэр бүхийн 23 албан хаагчдаас суутган авч бусад нэр зааж ангилагдаагүй орлогын төрийн сан банкны 100160000955 тоот дансанд 2023 оны 06 дугаар сарын 15-ны дотор төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2023 оны 06 дугаар сарын 25-ны дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Мал эмнэлэгийн газрын дарга Д.Батцэнгэл, нягтлан бодогч Л.Энхтуул нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН :

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.БОЛДБААТАР


АУДИТОР

С.ОЮУНЖАРГАЛ

04/2170430 тоот төлбөрийн актын хавсралт

№	Нэр	Илүү олгосон цаг	Актын дүн
1	Батцэнгэл	16	146,453.20
2	Гандолгор	16	84,085.68
3	Мөнхбаатар	16	126,062.16
4	Ууганцэцэг	16	97,935.36
5	Энх-амгалан	16	97,935.36
6	Дариймаа	8	33,251.68
7	Өнөржаргал	16	92,766.24
8	Энх-амгалан	16	99,753.60
9	Төрбат	16	97,935.36
10	Батжаргал	8	55,446.48
11	Хүрэлбаатар	16	94,093.44
12	Түмэнхүү	16	107,936.16
13	Ганбат	16	107,936.16
14	Тойлат	4	23,191.56
15	Амирхан	4	21,899.58
16	Алтанхүү	16	94,093.44
17	Одончимэг	4	23,523.36
18	Бахболат	4	23,523.36
19	Гансүх	16	107,936.16
20	Гагам-оролмаа	16	87,598.32
21	Тогтохбаяр	16	94,093.44
22	Энх-амгалан	4	23,523.36
23	Баярмаа	16	97,935.36
		292	1,840,909.02

Хавсралт үйлдсэн аудитор:



С.Оюунжаргал